

**ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРЫН ОЙН ТОГТВОРТОЙ
МЕНЕЖМЕНТ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ГҮЙЦЭТГЭЛД ХЯНАЛТ
ТАВИХ ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

**Монголын ойн тогтвортой менежментийн зөвлөл
Л.ДОРЖЦЭДЭН**

Цэцэрлэг хот
2020.09.04

Мэдээллийн агуулга

1. Хангайн нурууны байгалийн цогцолборт газрын товч танилцуулга
2. Хангайн нурууны байгалийн цогцолборт ойг хамгаалах менежментийг зохион байгуулах эрх зүйн орчин
 - ❖ Ойн тухай хууль. 2013 он шинэчилсэн найруулга
 - ❖ Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль 1995 он
 - ❖ Тусгай хамгаалалттай нутгийн Орчны бүсийн тухай Монгол Улсын хууль 1997 он



1. Хангайн нурууны байгалийн цогцолборт газрын товч танилцуулга

1.Хангайн нурууны байгалийн цогцолборт газар. УИХ-ын 1996 оны 43 тоот тогтоолоор Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймгуудын 11 сумын нутгыг хамарсан 888,455 га газрыг Улсын тусгай хамгаалалтад авчээ.

Тус цогцолборт газрын онцгой бүсийн А, Б бүсүүдийн хилийн заагийг Байгаль орчны сайдын 1998 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 143-р тушаалын хавсралтаар батласан.

2.Цэнхэр сум дахь Орчны бүс. Хангайн нурууны байгалийн цогцолборт газрын Орчны бүсийн хилийн заагийг Байгаль Орчны сайдын 2002 оны 12-р сарын 30-ны өдрийн 244-р тушаалын 4-р хавсралтаар баталсан. Ингэхдээ Архангай аймгийн Цэнхэр сумын орчны бүсийн хилийг хязгаарлалтын бүсийн хилийн заагтай давхацуулан тогтоожээ.

3. Хангайн нурууны байгалийн цогцолборт газрын ойн сан.


Хангайн нурууны ой нь Хангайн ой-ургамалжилтын мужийн зүүн өмнөд Хангайн хошуунд хамаарагдах тайгархаг, тайга, дэд тагийн ой юм. БЦГ-ын хэмжээнд ойн сан бүхий газар 177,737 га буюу нийт нутаг дэвсгэрийн 17 хувийг эзэлдэг

2. Хангайн нурууны байгалийн цогцолборт газрын ойг хамгаалах менежментийг зохион байгуулах эрх зүйн орчин

1. Ойн тухай хууль 2013 он /шинэчлэн найруулсан/

2. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль 1995 он,

3. Тусгай хамгаалалттай нутгийн Орчны бүсийн тухай Монгол Улсын хууль 1997 он



А.Ойн тухай хуулинд хамгаалалтын бүсийн ойг хамгаалах талаар

Ойн хуулийн 8 дугаар зүйлд хамгаалалтын бүсийн ой, түүний дэглэмийг дараахи байдлаар тодорхойлсон билээ. Үүнд:

1.Хамгаалалтын бүсийн ойд цармын бүслүүрийн ой, тусгай хамгаалалттай газрын болон сургалт, судалгааны зориулалттай ой, ногоон бүс, хориотой зурвасын ой, заган ой, баянбүрдийн ой, 100 га хүртэлх хэмжээний төгөл ой, бут, сөөг, 30 хэмээс илүү налуу газрын ой хамаарна.

2.Тусгай хамгаалалттай газар нутаг дахь ойн хамгаалалтын дэглэмийг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулна.

3.Хамгаалалтын бүсийн ойд зам, гүүр барих, ус, эрчим хүч, холбооны шугам татах болон түймрээс хамгаалах шороон зурвас гаргах, ойн хэвийн өсөлт, нөхөн сэргэлтийг дэмжихэд чиглэгдсэн арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх, ойн дагалт баялгийг ашиглахаас бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.



Ойн тухай хуулийн 21 дүгээр зүйлд ойн нөхөрлөл байгуулахад бүрдүүлэх бичиг баримт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр, Засаг даргатай ойн санг эзэмших гэрээ, нөхөрлөлийн эрх үүргийг тодорхой заасан байна.

Мөн энэ хуулинд гэрээ байгуулсан ойн нөхөрлөл дараах эрхийг эдлэхээр заажээ.Үүнд:

1.эзэмшлийн газартаа ойн менежментийн төлөвлөгөөний дагуу хийгдэх үйл ажиллагааг тасралтгүй явуулах

2.эзэмшлийн газраасаа ойн менежментийн төлөвлөгөө, эрхийн бичгийн дагуу бэлтгэсэн мод, ойн дагалт баялгийг ашиглах, хэрэгцээнээс илүү гарсан мод, ойн дагалт баялгийг худалдан борлуулах;

3.улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх ойн аж ахуйн арга хэмжээний төсөл, хөтөлбөр боловсруулах, санал өгөх, уралдаант шалгаруулалтад оролцох;

4.ойн менежментийн талаар явуулах сургалт, семинар, мэргэжил олгох, давтан сургах үйл ажиллагаанд хамрагдах.

21.13.Ойн нөхөрлөл энэ хуульд заасан үүргийг биелүүлэхийн зэрэгцээ тухайн шатны Засаг даргатай байгуулсан гэрээнд заасан үйл ажиллагааг явуулна.



Ойн тухай хуулийн 23 дугаар зүйлд ойн мэргэжлийн байгууллага, түүний үйл ажиллагаа, эрх үүргийг тодорхойлсон байна.

Ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд явуулах, арга зүйн зөвлөгөөгөөр хангах эрхийг холбогдох хуулийн дагуу авсан аж ахуйн нэгж, байгууллагыг ойн мэргэжлийн байгууллага гэнэ.

Ойн мэргэжлийн байгууллага нь ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшиж ойг зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх ажлыг гүйцэтгэх үүрэгтэй.



Б.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулинд ойг хамгаалах талаар

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн зорилт нь байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх,соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсч өөрчлөгдөх зүй тогтлыг судлах,танин мэдэх зорилгоор газар нутгийг тусгай хамгаалалтад авах, ашиглах, түүний унаган төрхийг хадгалах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль,Газрын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль,энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

Энэхүү хуулийн 3 дугаар зүйлд Улсын тусгай хамгаалалттай газар нутгийг дараахь байдлаар ангилна:

- 1/ дархан цаазат газар;
- 2/ байгалийн цогцолборт газар;
- 3/ байгалийн нөөц газар;
- 4/ дурсгалт газар.



Байгалийн цогцолбор газарт ойг хамгаалах үйл ажиллага явуулахтай холбоотой хуулийн зохицуулалтын авч үзье.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулинд байгалийн унаган төрхөө харьцангуй хадгалсан, түүх, соёл, шинжлэх ухааны болон танин мэдэхүй, экологийн хүмүүжилд ач холбогдол бүхий улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг байгалийн цогцолборт газар гэж тодорхойлжээ. Байгалийн цогцолборт газрыг байгалийн хэв шинж, ургамал, амьтны аймгийн байршил, түүх, соёлын дурсгалыг нь хадгалах шаардлага, аялал, жуулчлал хөгжүүлэх нөхцөл зэргийг харгалзан дараахь бүсэд хуваана:

1/ онцгой бүс;

2/ аялал, жуулчлалын бүс;

3/ хязгаарлалтын бүс.

Эдгээр бүс нь өөрийн аж ахуй эрхлэх дэглэмтэй юм.

Онцгой бүсэд байгалийн унаган төрхийг нь хадгалах шаардлагад нийцүүлэн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхийн зэрэгцээ байгальд сөрөг нөлөөгүй арга, хэлбэрээр судалгаа, шинжилгээний ажил явуулах, ургамал, амьтны өсч үржих нөхцөлийг хангах, хөрсийг нөхөн сэргээх, гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээ авна.

Харин Аялал, жуулчлалын болон хязгаарлалтын бүсэд ойд ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх болон сөрөг нөлөөгүй арга, хэлбэрээр судалгаа, шинжилгээний ажил явуулах, ургамал, амьтны өсч үржих нөхцөлийг хангах, хөрсийг нөхөн сэргээх, гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээ авах, зөвшөөрөгдсөн газар загас барих, уламжлалт аргаар мал аж ахуй эрхлэх зэрэг үйл ажиллагааг зөвшөөрдөг.



27 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2/ тусгай хамгаалалттай газар нутагт явуулах судалгаа, шинжилгээний ажлын журам, хөтөлбөрийг батлах, зөвшөөрөл олгох, холбогдох тайлан, мэдээллийг авч нэгдсэн санд оруулах;

3/ биологийн төрөл зүйлд судалгаа, тооллого явуулах, бүртгэл хөтлөх аргачлал, хөтөлбөрийг батлах, зөвшөөрөгдсөн бүсээс ажиглалтын зориулалтаар дээж, сорьц авах, хэмжилт хийх, сүргийн бүтцийг зохицуулах зорилгоор ан амьтныг агнах, барих журам тогтоох;

4/ ойг арчлах, ойжуулах, хөрс, ургамлыг нөхөн сэргээх журам, хөтөлбөрийг баталж, нөхөн сэргээх газрын хэмжээ, уг ажлыг гүйцэтгэх арга, технологийг тогтоох;

5/ хортон шавьж, мэрэгчид, түймрээс сэргийлэх, тэдгээртэй тэмцэх журам, аргачлал тогтоох, гамшиг болон аюулаас тусгай хамгаалалттай газар нутагт учирсан хор уршгийг багасгах арга хэмжээ авах;

30 дугаар зүйл. Дархан цаазат газар, байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны үйл ажиллагаа

Дархан цаазат газар, байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа /цаашид "хамгаалалтын захиргаа" гэх/ нь дараахь үйл ажиллагаа явуулна:

1/ тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх хууль тогтоомж, тухайн газар нутгийн хамгаалалтын горимын биелэлтийг хангуулах;

2/ судалгаа, шинжилгээ хийх зөвшөөрөл авсан байгууллагатай гэрээ байгуулах, тухайн газар нутгийн хамгаалалтын горимын хүрээнд явуулж болох үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох, хяналт тавих;

3/ зохих журмын дагуу судалгаа, шинжилгээний зориулалтаар дээж, сорьц авах, ан амьтны сүргийн бүтцийг зохицуулах, байгалийн баялгийг нөхөн сэргээх, ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх;



В.ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ОРЧНЫ БҮСИЙН ТУХАЙ ХУУЛИНД ОЙГ ХАМГААЛАХ ТАЛААР

Энэхүү хуулийн 3 дугаар зүйлд Дархан цаазат болон байгалийн цогцолборт газарт үзүүлж байгаа буюу үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг багасгах, арилгах, урьдчилан сэргийлэх, тухайн газар нутгийг хамгаалахад иргэдийн оролцоог өргөжүүлэх, тэдний ахуй амьдралаа баталгаажуулах, байгалийн баялгийг зохистой ашиглах шаардлагыг харгалзан тогтоосон газар нутгийг **орчны бүс** гэж тодорхойлжээ.

Орчны бүс нь дархан цаазат газрын хилийн заагийн гадна байх бөгөөд байгалийн цогцолбор газрын хувьд түүний хилийн заагийн гадна буюу хязгаарлалтын бүстэй нь давхцсан байж болно.

Мөн хуулийн Орчны бүсийн менежментийн төлөвлөгөө гэсэн 8 дугаар зүйлд:

8.1.Засаг дарга нь хамгаалалтын захиргаа, зөвлөлтэй хамтран энэ хуульд заасны дагуу орчны бүсийн менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

8.2.Орчны бүсийн менежментийн төлөвлөгөөнд дараахь зүйлийг тусгана:

8.2.1.нэн ховор, ховор ан амьтан, ургамал, түүнчлэн газар, байгалийн баялгийн хамгаалах, ашиглах чиглэл, хэрэгжүүлэх арга хэмжээ;

8.2.2.орчны бүсэд байгалийн нөөцийг зохистой ашиглах чиглэл, хэлбэр, уг үйл ажиллагаанаас тусгай хамгаалалттай газар нутаг, орчны бүсэд үзүүлэх нөлөөллийг багасгах арга хэмжээ;

8.2.3.иргэдийн ажил эрхлэлт, нийгмийн асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээ;

8.2.4.орчны бүсээр дамжин өнгөрдөг ан амьтан нүүдэллэх зам, түүнийг хамгаалах арга хэмжээ;

8.2.5.орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал, санхүүжүүлэх эх үүсвэр.

Мөн хуулийн 10 дугаар зүйлийн Орчны бүсийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт гэсэн хэсэгт хуулийн хэрэгжилтийн хяналтыг дараахи байдлаар хэрэгжүүлэхээр заажээ.


1.Орчны бүсэд явуулж байгаа үйл ажиллагаа, орчны бүсийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд орон нутгийн өөрөө удирдах болон төрийн холбогдох байгууллага хяналт тавина.

2.Зөвлөл нь орчны бүсэд хяналт хэрэгжүүлэхэд тухайн орон нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллагад туслалцаа үзүүлнэ.

3.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага орчны бүсийн хамгаалалт, байгаль орчны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх гомдлоо холбогдох хуульд заасан журмын дагуу шүүх, улсын байцаагч буюу зохих шатны Засаг даргад гаргана.

4.Улсын байцаагч, Засаг даргын гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргана.

Энэхүү хуулийн 11 дүгээр зүйлд энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

An aerial photograph of a vast, lush green forest valley. A river winds through the lower right portion of the scene. In the background, rolling mountains are visible under a clear sky. The text is overlaid in the center of the image.

Анхаарал тавьсанд
баярлалаа.